

1. Оршил

Энэхүү түүвэр судалгааны зорилго нь иргэд, аж ахуйн нэгжүүд (ААН) болон шинжээчдийн дунд инфляцийн хүлээлтийн талаар санал асуулга явуулж, тэдгээрийн хүлээлтийг тодорхойлоход оршино. Ингэснээр судалгааны үр дүнг цаашид мөнгөний бодлогын загварчлал болон бусад судалгаанд ашиглах боломжтой болох юм.

Монголбанкнаас анх удаагаа инфляцийн хүлээлтийн санал асуулгыг иргэдийн дунд 2008 оны 12 сард, ААН, шинжээчдийн дунд 2009 оны 3 сард явуулснаас хойш хоёрдахь санал асуулгыг зэрэг 2009 оны 9 сард, гуравдахийг 2010 оны 2 сард, дөрөвдэх буюу энэ удаагийнхыг 2010 оны 7 сард явууллаа.

Анхны санал асуулгаар иргэд, ААН ба шинжээчдийн хүлээлт нилээн өндөр гарсан нь тухайн үеийн санхүү, эдийн засгийн хямрал, инфляцийн өндөр түвшин зэрэг хүчин зүйлсээс хамааралтай байх талтай. Харин хоёр дахь удаагийн санал асуулга нь Улаанбаатар хотод дефляцитай үед явагдсан бөгөөд иргэд, ААН-үүд мөн адил бага хүлээлттэй байсан боловч шинжээчдийн хүлээлт өндөр гарсан байна. Харин гуравдахь санал асуулгаас иргэд болон ААН-үүдийн хагас жилийн хүлээлтийг тооцоолох асуултыг нэмж оруулсан бөгөөд санал асуулгын дүнгээр тухайн үеийн инфляцийн түвшнээс өсхөөр гарч байсан.

Энэ удаагийн санал асуулгад Улаанбаатар хотын 1000 иргэд, 390 ААН-үүд, 8 шинжээчид оролцлоо. Иргэдийн инфляцийн хүлээлт өмнөх судалгааны дүнгээс өсч оны эцэст **8.2** хувь, жилийн дараа гэхэд **8.6** хувь байхаар байна. Харин ААН-ийн инфляцийн хүлээлт оны эцсийн байдлаар **7.2** хувь, жилийн дараа гэхэд **6.9** хувь, шинжээчдийн хүлээлт 3-р улирлын эцэст **11.9** хувь, оны эцэст **11.7** хувь болохоор байна. Харин Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийг жилийн 8.0 хувиас хэтрүүлэхгүй байх зорилт тавьсан байгаа юм.

Санал асуулгад инфляцийн хүлээлтээс гадна нийгэм, эдийн засгийн талаарх асуултуудыг багтаадаг. Иргэдийн ихэнх хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд манай улсын эдийн засгийн байдал муудсан, бараг тал хувь нь хэвэндээ байна, муудна гэсэн хариултуудыг өгсөн хэвээр байгаа боловч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад багагүй хувиар буурч байна. Түүнчлэн судалгаанд оролцсон иргэдийн ихэнх нь Засгийн Газар эдийн засгийн байдлыг сайжруулах арга хэмжээ авч чадахгүй байна, ирэх нэг жилийн хугацаанд ажилгүйдэл нэмэгдэнэ гэж үзсэн ч өмнөхөөс дунджаар 10.0-11.0 нэгжээр буурсан дүнтэй байна.

Энэ удаагийн санал асуулгаар эдийн засаг сэргэж эхэлснийг илтгэх хэд хэдэн нааштай үзүүлэлтүүд гарсан байна. Өмнөх санал асуулгаар ААН байгууллагууд эдийн засгийн ерөнхий үзүүлэлтэд тааламжгүй, муу үнэлгээ өгч байсан бол энэ удаа сайжирсан гэж үнэлж эхэлсэн нь компаниудын бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт нэмэгдсэн, зээлийн олдоц сайжирсан, инфляцийн дарамт багассантай холбоотой байна.

Шинжээчдийн таамгаас харахад жилийн инфляци 2010 оны 3-р улиралд 11.9 хувь, оны эцэст 11.7 хувь болно гэсэн хүлээлттэй байгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад харгалзан 4.7 ба 4.8 нэгжээр өссөн байна. Бусад үзүүлэлтүүдийн хувьд 2010 онд бодлогын хүү тогтвортой, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарч, мөнгөний нийлүүлэлт нэмэгдэн, эдийн засаг өснө гэсэн хүлээлттэй байна.

2. Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны дүн

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2010 оны 7 дугаар сарын 15 өдрөөс 30 өдрийн хооронд явууллаа. Нийт 1000 иргэдээс санал асуулгыг авсан бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 26.9 хувь нь Баянзүрх, 21.8 хувь нь Сонгино-Хайрхан, 15.9 хувь нь Баянгол, 13.7 хувь нь Сүхбаатар, 11.1 хувь нь Чингэлтэй, 10.6 хувь нь Хан-Уул дүүргийн иргэд байлаа.

2.1. Хэрэглэгчдийн мэдээлэл

Хүснэгт 1. Асуулгад оролцсон хэрэглэгчдийн мэдээлэл

		Хариулсан хүний тоо	Нийт асуулгад оролцогчдод эзлэх хувь
Хүйс	Эрэгтэй	373	37.3%
	Эмэгтэй	627	62.7%
	Нийт	1000	100.0%
Нас	18-24	254	25.4%
	25-34	309	30.9%
	35-44	219	21.9%
	45-54	141	14.1%
	55-аас дээш	77	7.7%
	Нийт	1000	100.0%
	Боловсрол	Дээд	524
Бүрэн дунд		396	39.6%
Бүрэн бус дунд		76	7.6%
Бага		2	0.2%
Боловсролгүй		2	0.2%
Нийт		1000	100.0%
Ам бүлийн тоо	1	37	3.7%
	2-3	386	38.6%
	4-5	436	43.6%
	5-аас дээш	141	14.1%
	Нийт	1000	100.0%
Ажил эрхлэлт	Төрийн алба	147	14.7%
	Хувиараа	271	27.1%
	Хувийн байгууллага	342	34.2%
	Төрийн бус байгууллага	40	4.0%
	Цагийн ажил	28	2.8%
	Ажилгүй	160	16.0%
	Тэтгэвэрт	12	1.2%
	Нийт	1000	100.0%
Өрхийн орлого	100 мянгаас бага	75	7.5%
	101-200 мянга	162	16.2%
	201-300 мянга	257	25.7%
	301-400 мянга	218	21.8%
	401-500 мянга	137	13.7%
	500 мянгаас дээш	151	15.1%
	Нийт	1000	100.0%

Нийт судалгаанд оролцогчдын 62.7 хувь нь эмэгтэй байлаа. Насны бүтцээс харвал судалгаанд оролцогчдын 66.9 хувь буюу дийлэнх хэсэг нь 25-54 насны иргэд байгаа бөгөөд энэ насны иргэд нь худалдан авах шийдвэрээ бие дааж гаргах чадвартай, үнийн өсөлтөд илүү мэдрэмтгий иргэд гэж дүгнэлээ. Боловсролын түвшинг харахад 92.0 хувь нь бүрэн дунд болон дээд боловсролтой иргэд байна. Харин ам бүлийн тоог харвал нийт судалгаанд оролцогчдын 82.2 хувь нь 2-5 ам бүлтэй иргэд байлаа. Ажил эрхлэлтийн байдлыг харвал 61.3 хувь нь хувийн салбарт ажилладаг, 16.0 хувь нь ажилгүй иргэд байна. Харин судалгаанд оролцогчдын өрхийн орлогыг харвал 63.7 хувь нь 100-400 мянган төгрөгийн орлоготой иргэд байна. Тэр дундаа 41.9 хувь нь 100-300 мянган төгрөгийн өрхийн орлоготой иргэд байгаа нь үнийн өсөлтөд илүү мэдрэмтгий иргэд байлаа. Тус санал асуулгад эмэгтэй, 25-54 насны, бүрэн дунд болон дээд боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг, 100-400 мянган төгрөгийн орлоготой, 2-5 ам бүлтэй иргэд түлхүү оролцжээ.

2.2. Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгад хэрэглэгчдээс тодорхой тоон хариултыг авахгүй бөгөөд тэдний ирээдүйн инфляцийн таамаглалыг одоогийн инфляцийн түвшинтэй харьцуулан чанарын хариултаар авдаг. Дүнг хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 2. Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын гол асуултын дүн (12 сараар)

Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	2010 оны 2 сар		2010 оны 7 сар	
	Тоо	Хувиар	Тоо	Хувиар
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	312	30.7%	216	21.6%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	396	39.0%	388	38.8%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	102	10.0%	185	18.5%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	31	3.1%	50	5.0%
5. Үнэ буурна	5	0.5%	7	0.7%
6. Мэдэхгүй	169	16.7%	154	15.4%
Нийт	1015	100.0%	1000	100.0%

Чанарын хариултыг магадлалын аргаар тоон үзүүлэлт рүү шилжүүлэхэд иргэдийн жилийн инфляцийн хүлээлт **8.6** хувь байна. Өөрөөр хэлбэл иргэдийн хүлээлтээр 2011 оны 7 сарын эцэст жилийн инфляци одоогийн түвшнээс бага зэрэг буурна гэсэн хүлээлттэй байна. 2010 оны 2 дугаар сард явуулсан санал асуулгын дүнгээр хэрэглэгчдийн жилийн хүлээлт 5.3 хувь байсан.

Жилийн ХҮИ¹ 2009 оны 7-р сард 8.8 хувь байгаа нь 2009 оны эцсийнхтэй (12-р сард 1.9 хувьд хүрсэн) харьцуулахад нилээд өндөр түвшинд хүрчээ. Нэг талаас энэ өсөлт нь махны үнэ өмнөх жилийнхээс 30.6 хувиар өссөн нь жилийн эхэнд зуданд их хэмжээний мал

¹ Улаанбаатар хот

хорогдож махны хомсдол үүссэнтэй холбоотой. Мөн эрчим хүчний үнэ өссөн, Хятад улс будааны экспортдоо хориг тавьсан зэргээс шалтгаалан будааны үнэ өссөн зэрэг нь энэхүү өсөлтөнд нөлөөлсөн байх талтай. Нөгөө талаас энэхүү өсөлт нь Монгол улсын засгийн газраас бэлэн мөнгө тарааснаас (2-р сард 70,000 төгрөг) үүдэлтэй байж болно.

Хүснэгт 3. Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын гол асуултын дүн (6 сараар)

Таны бодлоор ирэх 6 сарын хугацаанд бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	2010 оны 2 сар		2010 оны 7 сар	
	Тоо	Хувиар	Тоо	Хувиар
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	329	32.4%	198	19.8%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	388	38.2%	412	41.2%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	127	12.5%	186	18.6%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	26	2.6%	68	6.8%
5. Үнэ буурна	13	1.3%	17	1.7%
6. Мэдэхгүй	132	13.0%	119	11.9%
Нийт	1015	100.0%	1000	100.0%

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн (хагас жилийн) чанарын хариултыг тоон үзүүлэлт рүү шилжүүлэн тооцоолоход **8.2** хувь байна. Өөрөөр хэлбэл иргэд 2010 оны эцэст инфляци уг түвшинд байна хэмээн хүлээж байгаа гэсэн үг юм. Энэ нь жилийн хүлээлтээс бага зэрэг доогуур байгаа бөгөөд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийг жилийн 8.0 хувьд барина гэж заасантай ойролцоо байна. Харин 2010 оны 2-р сард явуулсан санал асуулгын дүнгээр иргэдийн хагас жилийн хүлээлт 5.2 хувь байсан.

Дэлхийн эдийн засгийн байдал сайжирсан, ялангуяа хөгжиж буй орнуудын эрэлт идэвхжсэнээс шалтгаалан гол нэрийн түүхий эдийн үнэ өсч эхлээд байна. ОУВС хөгжингүй орнуудын хувьд 2010 онд инфляци 1.4 хувь, харин хөгжиж буй орнуудын хувьд 6.3 хувь байна гэж таамаглаж байна².

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт нь хүйс, боловсрол, ажил эрхлэлт, нас болон өрхийн орлогоос хамаарах магадлалтай юм. Тиймээс эдгээр хамаарлыг тодруулах үүднээс хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн гол асуултын дүнг ангилан авч үзлээ.

2.2.1. Хүйсийн ангилал

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт нь хүйсээс хамааран ялгавартай байж болох тул гол асуултын дүнг хүйсээр ангилж үзлээ. Нийт санал асуулгад оролцогчдын 62.7 хувь нь эмэгтэй, 37.3 хувь нь эрэгтэй байна.

² IMF. 2010 July, "World Economic Outlook Update - Restoring Confidence without Harming Recovery"

Хүснэгт 4. Хүйсийн ангиллаар (хувь)

Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Хүйс	
	Эрэгтэй	Эмэгтэй
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	21.2%	21.9%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	38.9%	38.8%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	17.4%	19.1%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	6.4%	4.1%
5. Үнэ буурна	1.3%	0.3%
6. Мэдэхгүй	14.7%	15.8%
Нийт	100.0%	100.0%

Хамгийн их нь буюу эрэгтэйчүүдийн 38.9 хувь, эмэгтэйчүүдийн 38.8 хувь нь 2-р хариултыг сонгосон бол 1-р хариултыг эрэгтэйчүүдийн 21.2 хувь, эмэгтэйчүүдийн 21.9 хувь нь тус тус сонгосон байна. Мөн 3-р хариултыг эрэгтэйчүүдийн 17.4 хувь нь, эмэгтэйчүүдийн 19.1 хувь нь сонгожээ. Мөн 4-р хариулт болох “үнэ өөрчлөгдөхгүй” гэсэн хариултанд эрэгтэйчүүдийн 6.4 хувь нь, эмэгтэйчүүдийн 4.1 хувь нь энэ хариултыг сонгожээ. Харин “үнэ буурна” гэж эрэгтэй хэрэглэгчдийн 1.3 хувь нь хариулсан байхад эмэгтэй хэрэглэгчид дөнгөж 0.3 хувь нь энэ хариултыг өгчээ. 6-р хариултыг харвал эрэгтэйчүүдийн 14.7 хувь, эмэгтэйчүүдийн 15.8 хувь хариулжээ. Хариултуудыг хүйсээр ангилан үзэхэд эрс ялгаа төдийлөн ажиглагдсангүй.

2.2.2. Насны бүлэг

Нийт санал асуулгад оролцогчдын 30.9 хувь нь 25-34 насны, 25.4 хувь нь 18-24, 21.9 хувь нь 35-44, 14.1 хувь нь 45-54 ба үлдсэн 7.7 хувь нь 55-аас дээш насны иргэд хамрагдсан байна.

Хүснэгт 5. Насны бүлгээр (хувь)

Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Насны бүлэг				
	18-24	25-34	35-44	45-54	55-аас дээш
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	19.7%	19.4%	21.9%	27.0%	26.0%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	41.7%	36.2%	37.4%	41.8%	37.7%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	18.9%	19.1%	21.9%	12.8%	15.6%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	3.9%	4.9%	5.0%	5.7%	7.8%
5. Үнэ буурна	1.6%	0.6%	0.5%	-	-
6. Мэдэхгүй	14.2%	19.7%	13.2%	12.8%	13.0%
Нийт	100%	100%	100%	100%	100%

Нийт судалгаанд оролцогчдын хамгийн их нь болох 25-34, 18-24 насны иргэдийн харгалзан 36.2 болон 41.7 хувь нь 2-р хариултыг сонгосон байхад 35-44 насны иргэдийн

37.4 хувь нь, 45-54 насны иргэдийн 41.8 хувь нь энэхүү хариултыг сонгосон байна. Мөн 6-р хариултыг 25-34 насныхны 19.7 хувь нь, 45-54 насныхны 12.8 хувь нь хариулсан нь 7.0 нэгжийн зөрүүтэй, 1-р хариултыг 45-54 насны иргэдийн 27.0 хувь, 25-34 насны иргэдийн 19.4 хувь хариулсан нь 7.5 нэгжийн зөрүүтэй, 3-р хариултыг 35-44 насны иргэдийн 21.9 хувь нь, 45-54 насныхны 12.8 хувь нь хариулсан нь 9.2 нэгжийн зөрүүтэй байна. Харин 4, ба 5-р хариултын хувьд зөрүү их биш байна. Эндээс харахад хамгийн их зөрүү ажиглагдсан нь 3-р хариулт байна.

2.2.3. Боловсролын түвшин

Гол асуултын дүнг боловсролын түвшингээр ангилан харууллаа. Нийт санал асуулгад оролцогчдын 52.4 хувь нь дээд, 39.6 хувь нь бүрэн дунд, 7.6 хувь нь бүрэн бус дунд, 0.2 хувь нь бага боловсролтой иргэд байсан бол 0.2 хувь нь боловсролгүй иргэд байлаа. Боловсролын түвшинг харахад судалгаанд оролцогчдын 92.0 хувь нь бүрэн дунд болон дээд боловсролтой иргэд байна.

Хүснэгт 6. Боловсролын түвшингээр (хувь)

Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Боловсролын түвшин				
	Дээд	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	Бага	Боловсролгүй
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	21.4%	21.2%	25.0%	-	50.0%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	42.2%	34.6%	38.2%	-	50.0%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	18.9%	19.7%	10.5%	-	-
4. Үнэ өөрчлөгдөхгүй	3.8%	6.1%	6.6%	50.0%	-
5. Үнэ буурна	0.8%	0.5%	1.3%	-	-
6. Мэдэхгүй	13.0%	17.9%	18.4%	50.0%	-
Нийт	100%	100%	100%	100%	100%

Нийт судалгаанд оролцсон иргэдээс хамгийн их нь болох дээд боловсролтой иргэдийн 42.2 хувь нь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 34.6 хувь нь 2-р хариултыг сонгосон байна. 1-р хариултыг харвал дээд боловсролтой иргэдийн 21.4 хувь нь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 21.2 хувь нь энэ хариултыг сонгосон бөгөөд бусад хариултуудын хувьд дээд болон бүрэн дунд боловсролтой иргэдийн хооронд ялгаа төдийлэн ажиглагдахгүй байна.

Бага боловсролтой болон боловсролгүй иргэдийн хувьд нийт санал асуулгад оролцогчдод маш бага хувийн жин эзэлж байгаа бөгөөд боловсролгүй иргэд 1 болон 2-р хариултад, бага боловсролтой иргэд 4 болон 6-р хариултад саналаа өгчээ. Эндээс харахад судалгаанд оролцогчдын ихэнх нь дээд, бүрэн дунд боловсролтой иргэд байсан бөгөөд хариултуудын хувьд боловсролын ялгаа төдийлэн ажиглагдсангүй, харин 2-р хариултын хувьд 7.6 нэгжээр зөрүүтэй хариулсан нь энэ хоёр ангиллын хувьд хамгийн их нь байлаа.

2.2.4. Ажил эрхлэлт

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт нь ажил эрхлэлтийн байдлаас хамааран ялгавартай байж болох тул гол асуултын дүнг ажил эрхлэлтээр ангилан харуулах нь зүйтэй. ҮСХ-ны мэдээгээр 2009 оны эцэст Монгол улсын хүн ам 2 сая 736.8 мянган хүн ам байснаас хөдөлмөрийн насны хүн ам 1 сая 823.5 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч 1 сая 120.3 мянга байсан бөгөөд үүний 977.4 мянга нь ажиллагсад байна. Харин нийт судалгаанд оролцогсдын 27.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 34.2 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 16.0 хувь нь ажилгүй, 14.7 хувь нь төрийн байгууллагад, 4.0 хувь нь төрийн бус байгууллагад, 2.8 хувь нь цагийн ажил эрхэлдэг, 1.2 хувь нь тэтгэвэрт гарсан иргэд байлаа.

Хүснэгт 7. Ажил эрхлэлтээр (хувь)

Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Ажил эрхлэлт						
	Төрийн алба	Хувиараа	Хувийн багууллага	Төрийн бус байгууллага	Цагийн ажил	Ажилгүй	Тэтгэвэрт
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	25.2%	19.9%	20.5%	17.5%	25.0%	23.8%	25.0%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	38.1%	38.4%	41.5%	40.0%	32.1%	35.0%	41.7%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	18.4%	18.1%	19.3%	20.0%	21.4%	17.5%	8.3%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	6.8%	4.8%	3.8%	7.5%	3.6%	5.0%	16.7%
5. Үнэ буурна	1.4%	1.1%	0.3%	-	-	0.6%	-
6. Мэдэхгүй	10.2%	17.7%	14.6%	15.0%	17.9%	18.1%	8.3%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%

1-р хариулт буюу үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө гэж төрийн албанд ажиллагсдын 25.2 хувь үзсэн бол түүнээс 5.2 нэгжээр бага буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 19.9 хувь нь ийнхүү хариулжээ. Мөн хувийн байгууллагад ажиллагсдын 41.5 хувь нь 2-р хариултыг сонгосон байхад ажилгүйчүүд тэдгээрээс 6.5 нэгжээр бага хариулсан нь хамгийн бага байна. Үлдсэн хариултуудын хувьд ажил эрхлэлтийн ялгаа төдийлэн их биш байна.

Судалгаанд оролцогчдод харьцангуй бага хувийн жин эзэлж буй тэтгэврийн иргэдийн 40 гаруй хувь нь үнийн өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй гэж хариулсан байхад төрийн бус байгууллагад ажиллагсын 40 хувь, цагийн ажил эрхлэгчдийн гуравны нэг нь ийнхүү хариулжээ. Бусад хариултуудад их ялгаа ажиглагдсангүй.

2.2.5. Өрхийн орлого

Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт өрхийн орлогоос хамаарч байгаа эсэхийг тодруулах үүднээс гол асуултын дүнг өрхийн орлогоор ангиллаа. ҮСХ-ны мэдээгээр нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2010 оны 2-р улирлын эцэст 338.6 мянган төгрөг болж 2009 оны мөн үеийнхээс 9.5 хувь буюу 29.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт санал асуулгад оролцогчдын 25.7 хувь нь 201.0-300.0 мянга, 16.2 хувь нь 101.0-200.0 мянга, 7.5 хувь нь 100.0 мянгаас бага төгрөгийн орлоготой иргэд байсан нь улсын дунджаас доогуур орлоготой иргэд байна. Харин 21.8 хувь нь 301.0-400.0 мянган төгрөгийн буюу дундаж орлоготой, 13.7 хувь нь 401.0-500.0 мянга, 15.1 хувь нь 500 мянгаас дээш төгрөгийн орлоготой байгаа нь улсын дунджаас дээгүүр орлоготой байна. Эндээс харвал судалгаанд оролцогчдын 63.7 хувь нь 100.0-400.0 мянган төгрөгийн орлоготой иргэд байна. Тэр дундаа 41.9 хувь нь 100.0-300.0 мянган төгрөгийн өрхийн орлоготой иргэд байгаа нь үнийн өсөлтөд илүү мэдрэмтгий иргэд байлаа.

Хүснэгт 8. Өрхийн орлогоор (хувь)

Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ?	Өрхийн орлого					
	100.0-аас бага	101.0-200.0	201.0-300.0	301.0-400.0	401.0-500.0	500.0-аас дээш
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	28.0%	25.3%	19.8%	21.6%	14.6%	23.8%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	26.7%	29.6%	41.2%	39.9%	46.0%	42.4%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	13.3%	17.9%	18.3%	21.1%	21.2%	15.9%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	8.0%	5.6%	4.3%	4.1%	5.1%	5.3%
5. Үнэ буурна	1.3%	.6%	.4%	1.4%	.7%	
6. Мэдэхгүй	22.7%	21.0%	16.0%	11.9%	12.4%	12.6%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%

Үнийг хурдацтай өснө гэж 100.0 мянгаас бага орлоготой иргэдийн 28.0 хувь нь хариулсан байхад 401.0-500.0 мянган төгрөгийн орлоготой иргэд тэднээс 13.4 нэгжээр бага хариулсан нь хамгийн бага байгаа бөгөөд эсрэгээрээ 2-р хариултыг тэдний 46.0 хувь нь хариулсан нь хамгийн их бөгөөд 100.0 мянгаас бага орлоготой иргэд тэднээс 19.3 нэгжээр багаар хариулсан нь хамгийн бага нь байлаа. 3-р хариултыг харвал 401.0-500.0 мянган орлоготой иргэдийн 17.2 хувь нь сонгосон байхад 100.0 мянгаас бага орлоготой иргэд тэднээс 7.8 нэгжээр багаар хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 100.0 мянгаас бага орлоготой иргэдийн 22.7 хувь нь хариулсан байхад 301.0-400.0 мянган орлоготой иргэдийн 11.9 хувь нь хариулсан нь хамгийн бага байна. Харин 4 болон 5 дугаар хариултуудын хувьд орлогын ялгаа төдийлэн ажиглагдахгүй байна.

2.3. Бусад асуултуудын дүн

Хүснэгт 9. Таны бодлоор манай улсын эдийн засаг өнгөрсөн 12 сарын хугацаанд сайжирсан уу?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Сайжирсан	3.6	9.7	6.1
Хэвэндээ байна	27.7	39.8	12.1
Муудсан	57.1	40.9	-16.2
Мэдэхгүй	11.5	9.6	-1.9
Нийт	100.0	100.0	-

Судалгаанд оролцогчдын 40 гаруй хувь нь манай улсын эдийн засаг өнгөрсөн онд “муудсан” гэж үзсэн бөгөөд энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 16.2 нэгжээр буурсан байна. Харин 39.8 хувь нь “хэвэндээ байна” гэж, харин 9.7 хувь нь “сайжирсан” гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 6.1 нэгжээр өссөн байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд эдийн засгийн хямралын нөлөөгөөр эдийн засгийн салбарууд зогсонги байдалд орсон, мөн өрхийн орлого багасч иргэдийн худалдан авах чадвар муудсан зэрэг олон сөрөг нөлөөллүүд гарсан. 2009 оны эцэст ДНБ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 хувиар буурсан ч 2010 оны 1-р улиралд 7.5 хувиар, 2-р улиралд 5.0 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлт харьцангуй сэргэж байгаагийн илрэл юм. Уг өсөлтөд аж үйлдвэр, барилгын салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний салбар болон бүтээгдэхүүний татварын хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 10. Таны бодлоор манай улсын эдийн засаг ирэх 12 сарын хугацаанд ямар байх бол?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Сайжирна	5.8	8.6	2.8
Сайжрах нөхцөл бүрдэнэ	19.4	22.9	3.5
Хэвэндээ байна	27.6	33.4	5.8
Муудах байх	21.7	13.4	-8.3
Мэдэхгүй	25.5	21.7	-3.8
Нийт	100.0	100.0	-

Нийт судалгаанд оролцогчдын 46.8 хувь нь “хэвэндээ байна”, “муудах байх” гэж хариулсан нь хувийн жингээрээ өмнөх судалгааны дүнгээс 2.5 нэгжээр буурсан байна. Харин 31.5 хувь нь “сайжирна”, “сайжрах нөхцөл бүрдэнэ” гэж хариулсан нь хувийн жингээр өмнөхөөсөө 6.3 нэгжээр өсчээ.

2010 онд манай улсын эдийн засаг 7.4 хувиар өснө гэж Сангийн яам болон олон улсын санхүүгийн байгууллагууд үзэж байна³. Хэдийгээр өнгөрсөн онд ДНБ-ий уналт саарч өсч эхэлсэн, Засгийн газраас уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэнд

³ Нээлттэй нийгэм форум. 2010, “Дэлхийн санхүү эдийн засгийн Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө”

оруулах гэрээ хэлэлцээрүүдийг хийж хөрөнгө оруулалтуудыг хийж эхэлсэн хэдий ч иргэдийн бараг тал хувь нь ирэх нэг жилд эдийн засаг муудна гэж үзсэн хэвээр байна.

Хүснэгт 11. Засгийн газар эдийн засгийн байдлыг сайжруулах арга хэмжээ авч чадаж байна уу?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Чадаж байна	1.7	3.7	2.0
Дунд зэрэг байна	23.5	34.0	10.5
Чадахгүй байна	66.2	55.1	-11.1
Мэдэхгүй	8.6	7.2	-1.4
Нийт	100.0	100.0	-

Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 89.1 хувь нь Засгийн газрын эдийн засгийн талаар авч байгаа бодлого арга хэмжээнд ихээхэн шүүмжлэлтэй хандаж байгаа нь харагдаж байна. Гэвч “чадахгүй байна” гэж үзсэн иргэдийн тоо өмнөх судалгаатай харьцуулахад 11.1 нэгжээр буурч, “дунд зэрэг байна” гэсэн хариулт 10.5 нэгжээр өссөн дүнтэй байна.

Манай улсын хувьд 2008 оны сүүлийн улирал ашигт малтмалын үнэ огцом унасны улмаас үүдэн төсөв ноцтой хүндэрсний дараа 2009 оны дунд үеэс эхлэн төсвийн тэнцэлд нааштай үзүүлэлтүүд гарч эхэлсэн. Гэвч энэхүү сэргэлт нь 2009 оны сүүлээс Засгийн газрын зардал нэмэгдснээс зогсонги байдалд орсон. 2010 оны 2-р сард иргэн бүрт 70,000 төгрөгийг бэлнээр олгосон ч жилийн үлдэж буй 5 сард ахин 50,000 төгрөгийг бэлнээр тараахаар шийдвэрлэсэн. Түүнчлэн 10-р сарын 1-с эхлэн цалин тэтгэврийг 30 хувь нэмэхээр болоод байгаа билээ.

Хүснэгт 12. Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд ажилгүйдэл нэмэгдэх үү?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Нэмэгдэнэ	52.1	41.3	-10.8
Хэвэндээ байна	20.0	29.0	9.0
Буурна	8.0	10.5	2.5
Мэдэхгүй	19.9	19.2	-0.7
Нийт	100.0	100.0	-

Нийт судалгаанд оролцогчдын 41.3 хувь нь ажилгүйдэл нэмэгдэнэ гэж хариулсан бөгөөд өмнөх судалгааны дүнгээс 10.8 нэгжээр буурсан дүнтэй байна. Дэлхийн хөдөлмөрийн байгууллагын мэдээлснээр санхүү, эдийн засгийн хямралын улмаас 2009 онд ажилгүйчүүдийн тоо дэлхийн хэмжээнд 30.0 саяд хүрнэ хэмээн таамаглаж байсан бол 2010 оны 1 дүгээр сарын байдлаар ажилгүйчүүдийн тоо 212.0 саяд хүрсэн байна⁴. Манай улсын хувьд ҮСХ-ны мэдээгээр 2010 оны 7 дугаар сарын эцэст ажил идэвхтэй хайж

⁴ International Labour Organization. 2010, Global Employment Trend.

байгаа ажилгүй иргэдийн тоо 39.2 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.7 хувиар буурчээ.

Хүснэгт 13. Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү өсөх үү?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Өснө	25.3	21.0	-4.3
Хэвэндээ байна	25.4	31.2	5.8
Буурна	9.5	10.8	1.3
Мэдэхгүй	39.8	37.0	-2.8
Нийт	100.0	100.0	-

Нийт судалгаанд оролцогчдын 21.0 хувь нь “өснө” гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 4.3 нэгжээр буурсан бөгөөд “хэвэндээ байна” гэж 31.2 хувь нь хариулж өмнөхөөс 5.8 нэгжээр өссөн байна. Зээлийн нэрлэсэн хүүний түвшин нь инфляци болон бодит хүүний түвшнээс бүрдэнэ. 2009 оны эцэст Монголбанкнаас явуулсан мөнгөний бодлогын дүнд инфляцийн түвшин тогворжиж нам түвшинд очсон хэдий ч 2010 оны эхний 7 сарын байдлаар оны эхнээс хоёр оронтой тоонд хүрсэн байна. Мөн нөгөө талаас хямралаас шалтгаалан банкуудын зээлийн эргэн төлөлт зогссон нь зээлийн хүүгээ өсгөхөд хүргээд байсан билээ.

Хүснэгт 14. Таны бодлоор эдийн засгийн ерөнхий байдлыг авч үзвэл одоо хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Тийм	10.6	17.1	6.5
Үгүй	56.0	46.0	-10.0
Мэдэхгүй	33.4	36.9	3.5
Нийт	100.0	100.0	-

Судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь тохиромжгүй гэж үзэж байгаа хэдий ч өмнөх судалгааны дүнгээс 10.0 нэгжээр буурсан дүнтэй байна. 2010 оны эхний 7 сарын байдлаар инфляцийн түвшин өссөн болов ч хадгаламжийн бодит хүү эерэг түвшинд байна⁵. Тоо баримтаас харахад нийт харилцах, хадгаламж 2008 оны эцсээс багасч жилийн өсөлт нь харгалзан -4.1 болон -10.1 хувьд хүрээд байсан бол 2009 оны эцсээс эргэн нэмэгдэж 2010 оны 7 сарын байдлаар 34.4 болон 65.0 хувиар өсөөд байгаа бөгөөд “тийм” гэсэн хариулт өмнөх судалгаанаас 6.5 нэгжээр өсч 17.1 хувьд хүрээд байна. Энэ нь банкны хадгаламжийг хариуцах “бүрэн баталгааны хуулиар” тайлбарлагдаж болох юм.

⁵ 2010 оны 7 сарын байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс инфляцийн түвшинг хасаж тооцсон бодит хүү 2.9 хувь байна.

Хүснэгт 15. Таны бодлоор одоо томоохон хэмжээний худалдан авалт хийхэд тохиромжтой үе мөн үү?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Тийм	3.6	7.4	3.8
Магадгүй	19.9	25.8	5.9
Үгүй	58.6	48.0	-10.6
Мэдэхгүй	17.8	18.8	1.0
Нийт	100.0	100.0	0.0

Нийт судалгаанд оролцсон иргэдийн бараг тал хувь нь буюу 48.0 хувь нь тохиромжгүй гэж үзсэн бөгөөд энэ нь өмнөх судалгаанаас 10.6 нэгжээр буурч харин тохиромжтой, магадгүй гэсэн иргэдийн хувийн жин өмнөхөөс 9.7 нэгжээр өссөн байна. Эдийн засгийн хямралын нөлөөгөөр байгууллагын цалин хөлс нэмэгдээгүй нь өмнөх жилүүдийн өндөр инфляцийн түвшин хадгалагдсаар байгаагийн илрэл бөгөөд энэ нь иргэдийн бодит орлогыг бууруулсан. Үүний улмаас иргэдийн худалдан авах чадвар ихээр буурч томоохон хэмжээний худалдан авалт хийх боломж муудсан байна. Нөгөө талаас иргэдийн ихэнх нь томоохон хэмжээний худалдан авалтыг банкны зээлээр хийдэг бөгөөд өнгөрсөн нэг жилд арилжааны банкуудын зээлийн эргэн төлөлт муудсанаас банкууд зээлийн хүүгээ өсгөхөөс гадна, шинээр олгох зээлийн хэмжээгээ эрс бууруулаад байсан билээ.

Хүснэгт 16. Танай өрхийн санхүүгийн байдал өнгөрсөн 12 сарын хугацаанд ямар байсан бэ?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Сайжирсан	7.1	10.7	3.6
Хэвэндээ	47.5	55.6	8.1
Муудсан	43.3	31.3	-12.0
Мэдэхгүй	2.1	2.4	0.3
Нийт	100.0	100.0	-

Нийт судалгаанд оролцсон иргэдийн гуравны нэг нь буюу 31.3 хувь нь “муудсан” гэж хариулсан бөгөөд өмнөх судалгааны дүнгээс 12.0 нэгжээр буурсан байна. Харин “хэвэндээ байна” гэсэн хариулт 8.1 нэгжээр, “сайжирсан” гэсэн хариулт 3.6 нэгжээр тус тус өссөн дүнтэй байна.

Санхүүгийн байдал нь муудсан иргэдийн хувь багагүй жин эзэлж байгаа ч өмнөх судалгааны дүнгээс нилээд буурсан нь сайшаалтай юм. Эдийн засгийн хямралын томоохон сөрөг нөлөө нь хөгжиж буй орнуудын хувьд ядуурлын түвшин огцом өссөнөөр илэрсэн. Дэлхийн банкны судалгаагаар хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт нэг пунктээр буурахад ядуучуудын тоо 20 гаруй саяар нэмэгддэг гэжээ⁶. Тэгвэл өнгөрсөн онд хөгжиж буй орнуудын өсөлт 2.2 нэгжээр буурчээ. Хамгийн сүүлийн судалгаагаар Монгол улсад 2008 оны байдлаар ядуурлын түвшин 35.2⁷ (930,000 хүн) хувьтай байгаа бөгөөд нэг

⁶ Нээлттэй нийгэм форум. 2010, “Дэлхийн санхүү эдийн засгийн Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө”

⁷ UNFPA, 2009. Монгол улс хүн ам ба хөгжлийн бага хурлаас хойших 15 жилд

хүнд ноогдох хэрэглээнд тулгуурлаж тооцдог хэрэглээний тэгш бус байдлыг харуулдаг жини коэффициент⁸ сүүлийн жилүүдэд өсч байгаа нь (2008 оны байдлаар 0.36) эдийн засгийн баялгийн үр шимийг амьдралын боломж илүү сайтай хүмүүс хүртэж байгаагийн илэрхийлэл юм.

Хүснэгт 17. Хэрэв сайжирсан бол шалтгаан нь юу вэ?

	Тоо	Хувь
Цалин нэмэгдсэн	33	3.3
Бизнесийн орлого нэмэгдсэн	40	4.0
Үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөн	9	0.9
Өрхийн гишүүн ажлын байртай болсон	37	3.7
Үнэ буурсан	5	0.5
Төрөөс тэтгэмж, тэтгэлэг авах болсон	8	0.8
Хамаатан, найз нараас тусламж авсан	7	0.7
Татварын хөнгөлөлт чөлөөлөлт хүртсэн	1	0.1
Нийт	140	14.0

Сайжирсан гэж иргэдийн 10.7 хувь нь хариулсан бөгөөд давхардсан тоогоор тэдгээр хэрэглэгчдийн ихэнх нь бизнесийн орлого нэмэгдсэн, цалин нэмэгдсэн, өрхийн гишүүд ажлын байртай болсон зэрэг шалтгаануудыг дурдсан байна.

Хүснэгт 18. Хэрэв муудсан бол шалтгаан нь юу вэ?

	Тоо	Хувь
Цалин буурсан	50	5.0
Бизнесийн орлого буурсан	63	6.3
Үл хөдлөх хөрөнгийн үнэ буурсан	17	1.7
Өрхийн гишүүн ажилгүй болсон	85	8.5
Үнэ өссөн	213	21.3
Бусдад санхүүгийн тусламж үзүүлсэн	16	1.6
Татварын ачаалал ихэссэн	28	2.8
Нийт	472	47.2

Муудсан гэж нийт судалгаанд оролцогчдын 31.3 хувь нь хариулсан бөгөөд тэдгээрээс давхардсан тоогоор ихэнх нь үнэ өссөнөөс, өрхийн гишүүн ажлын байргүй болсноос, бизнесийн орлого буурснаас, мөн цалин буурсны улмаас шалтгаалсан гэжээ.

⁸ 0 утга нь тэгш бус байдал байхгүйг, 1 гэсэн утга нь тэгш бус байдал дээд цэгтээ байгааг тус тус илэрхийлнэ

Хүснэгт 19. Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд сайжрах уу?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Сайжирна	22.2	26.9	4.7
Хэвэндээ байна	33.8	39.6	5.8
Муудна	9.7	6.3	-3.4
Мэдэхгүй	34.3	27.2	-7.1
Нийт	100.0	100.0	-

Нийт судалгаанд оролцсон иргэдийн 27.2 хувь нь “мэдэхгүй” гэж хариулсан бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 7.1 нэгжээр буурсан байна. Хямралаас үүдэн ирээдүйн тодорхой бус байдал ихээр нэмэгдэж байсан боловч дэлхийн эдийн засаг сэргэх төлөв байдалтай болж ирсэн нь хариултын хувь хэмжээ буурахад нөлөөлсөн байж болох юм. “Хэвэндээ байна” гэж иргэдийн 39.6 хувь нь хариулсан бөгөөд хувийн жингээрээ өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 5.8 нэгжээр өссөн байна. Харин “сайжирна” гэсэн хариулт өмнөхөөс 4.7 нэгжээр өсч “муудна” гэсэн хариулт 3.4 нэгжээр буурсан байна.

Хүснэгт 20. Хэрэв сайжрах бол шалтгаан нь юу вэ?

	Тоо	Хувь
Цалин нэмэгдэнэ	113	11.3
Бизнесийн орлого нэмэгдэнэ	110	11.0
Үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө	15	1.5
Өрхийн гишүүн ажлын байртай болно	90	9.0
Үнэ буурна	30	3.0
Төрөөс тэтгэмж, тэтгэлэг авна	27	2.7
Хамаатан, найз нараас тусламж авна	11	1.1
Татварын хөнгөлөлт чөлөөлөлт хүртэнэ	10	1.0
Нийт	406	40.6

“Сайжирна” гэж судалгаанд оролцсон иргэдийн 26.9 хувь нь хариулсан бөгөөд давхардсан тоогоор тэдгээрийн ихэнх нь ирээдүйн бизнесийн орлого нэмэгдэнэ, цалин нэмэгдэнэ, өрхийн гишүүд ажлын байртай болно гэж үзсэн байна.

Хүснэгт 21. Хэрэв муудах бол шалтгаан нь юу вэ?

	Тоо	Хувь
Цалин буурна	7	0.7
Бизнесийн орлого буурна	12	1.2
Үл хөдлөх хөрөнгийн үнэ буурна	6	0.6
Өрхийн гишүүн ажилгүй болно	16	1.6
Үнэ өснө	43	4.3
Бусдад санхүүгийн тусламж үзүүлнэ	7	0.7
Татварын ачаалал ихэснэ	11	1.1
Нийт	102	10.2

“Муудна” гэж иргэдийн 6.3 хувь нь хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс буурсан бөгөөд давхардсан тоогоор тэдгээрийн ихэнх нь үнэ өссөнөөс, татварын ачаалал ихэссэнээс, цалин буурснаас шалтгаалан санхүүгийн байдал муудна гэж үзсэн байна.

Хүснэгт 22. Та Монголбанкны мэдээлэл, зорилтот үзүүлэлтүүдэд итгэдэг үү?

	2010 он 2 сар	2010 он 7 сар	Өөрчлөлт
Тийм	8.2	14.3	6.1
Бага зэрэг	35.9	38.6	2.7
Үгүй	36.6	28.3	-8.3
Мэдэхгүй	19.4	18.8	-0.6
Нийт	100.0	100.0	-

Нийт судалгаанд оролцогчдын 28.3 хувь нь итгэдэггүй гэсэн хариултыг өгсөн боловч энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 8.3 нэгжээр буурсан байна. Харин “тийм” болон “бага зэрэг” итгэдэг гэсэн хариултууд хувийн жингээрээ өмнөх судалгаанаас 8.8 нэгжээр өссөч 52.9 хувьд хүрсэн байна. Өнгөрсөн 2009 онд Монголбанк мөнгөний бодлогын гол зорилго (инфляцийг нэг оронтой тоонд барих) –оо биелүүлж, үнийн өсөлтийг тогтворжуулсан хэдий ч банкны салбар нилээдгүй тогтворгүй орчинд үйл ажиллагаа явуулж байна. Мөн Монголбанк гадаад валютын үнэ хаялцуулах систем нэвтрүүлснээр 2009 оны 4-р сараас хойш ам.долларын ханш тогтвортой хэвээр байна.

3. Аж ахуйн нэгж, байгууллагуудын инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүн

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан инфляцийн хүлээлтийн 2010 оны 3 дугаар улирлын санал асуулгад Улаанбаатар хотын 390 байгууллага оролцлоо. Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийн 94,4 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 1,5 хувь нь хувьцаат компани, 1,3 хувь нь зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 1 хувь нь хоршоо болон төрийн өмчит үйлдвэрийн газрууд байна.

Хүснэгт 23. Асуулганд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээлэл

		Хариулсан тоо	Нийт асуулгад эзлэх хувь
1. Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	2	0,5%
	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	5	1,3%
	Хоршоо	4	1,0%
	Хувьцаат компани	6	1,5%
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	368	94,4%
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	4	1,0%
	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	1	0,3%
	Бусад	0	0,0%
2. Охин компанитай эсэх	Тийм	35	9,0%
	Үгүй	355	91,0%
3. Үйл ажиллагааны чиглэл	Хөдөө аж ахуй	8	2,1%
	Барилга	29	7,4%
	Худалдаа	97	24,9%
	Үйлчилгээ	107	27,4%
	Зочид буудал, зоогийн газар	63	16,2%
	Тээвэр	20	5,1%
	Үйлдвэрлэл	66	16,9%
Нийт		390	100%


Санал асуулгад оролцогсдыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилбал 27,9 хувь нь үйлчилгээ, 24,9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 16,9 хувь нь үйлдвэрлэл, 16,2 хувь нь зочид буудал, зоогийн газар, 7,4 хувь нь барилга, 5,1 хувь нь тээвэр, 2,1 хувь нь хөдөө аж ахуйн салбарт харьяалж байна.

Хүснэгт 24. Санал асуулгад оролцсон компаниудын ажилчдын тоо

10 хүртэл	184	47,2%
11-50	152	39,0%
51-250	40	10,3%
250аас дээш	13	3,3%
1000аас дээш	1	0,3%
Нийт	390	100%

Ажилчдын тоогоор нь авч үзвэл нийт санал асуулгад оролцогч аж ахуйн нэгжүүдийн 47,2 хувь нь 10 хүртэл тооны, 39 хувь нь 11-ээс 50 хүртэл тооны ажилчидтай байгууллагууд байна. Харин хөрөнгө оруулалтын хувьд 88,8 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай, 7,9 хувь нь дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай, 3,3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байгаа бол бүтээгдэхүүн/үйлчилгээний хувьд 72,8 хувь нь дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг, 17,7 хувь нь дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэж үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ гадаадаас импортолдог, 9,5 хувь зөвхөн гадаадаас импортолдог байна.

Зураг 1. Судалгаанд оролцсон компаниудын хөрөнгө оруулалт болон бүтээгдэхүүн/үйлчилгээний төрөл



3.1. Бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт өнгөрсөн 6 сарын хувьд хэрхэн өөрчлөгдсөн бэ гэсэн асуултанд 32.8 хувь нь өссөн, 45.4 хувь нь өөрчлөгдөөгүй, 21.8 хувь нь буурсан гэж хариулсан нь өмнөх судалгааны буюу 2010 оны I улирлын санал асуулгатай харьцуулахад өссөн гэсэн хариулт дариу 15.8 хувиар өсч, буурсан гэсэн хариулт 30.7 хувиар буурсан нь 2010 онд Монгол улсын эдийн засаг сэргэж

худалдан авалт нэмэгдсэнийг харуулж байна. Өнгөрсөн санал асуулгатай харьцуулахад гадаадын бараа бүтээгдэхүүний эрэлт өнгөрсөн 6 сард өөрчлөгдөөгүй бол дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, тэр дундаа дотооддоо үйлдвэрлэхийн зэрэгцээ гадаадаас бараа бүтээгдэхүүн импортлодог компаниудын эрэлт 15.8-аас 21.5 хувиар өссөн байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүн энэ онд өсөлттэй гарахыг харуулж байна.

Хүснэгт 25. Өнгөрсөн 6 сарын хугацаанд танай компанийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт хэрхэн өөрчлөгдсөн бэ?

		Өссөн	Өөрчлөгдөөгүй	Буурсан	Хариулаагүй
Дотооддоо үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг	2010.I	16,6	31,2	52,3	0
	2010.III	32,4	44,7	22,9	0
	Өөрчлөлт	15,8	13,5	-29,4	0,0
Импортлодог	2010.I	23,4	25,5	51,1	0
	2010.III	32,4	56,8	10,8	0
	Өөрчлөлт	9,0	31,3	-40,3	0
Аль аль нь	2010.I	13,3	31,1	55,6	2,3
	2010.III	34,8	42,0	23,2	0
	Өөрчлөлт	21,5	10,9	-32,4	-2,3
Бүгд	2010.I	17,0	30,5	52,5	0,5
	2010.III	32,8	45,4	21,8	0
	Өөрчлөлт	15,8	14,9	-30,7	-0,5

Харин ирэх 6 сарын хүлээлтийг сонирхоход санал асуулгад оролцогсдын 37.2 хувь нь өснө, 23.1 хувь нь өөрчлөгдөхгүй, 29 хувь нь мэдэхгүй, 10.8 хувь нь буурна гэж хариулсан байгаа нь өмнөх санал асуулгатай харьцуулахад өснө гэсэн хариулт 8.2 хувиар, өөрчлөгдөхгүй гэсэн хариулт 4.6 хувиар өсч мэдэхгүй гэсэн хариулт 12.5 хувиар буурчээ. Аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр нь ангилбал дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг компаниудын хүлээлт өмнөх асуулгаас 10.7 хувиар өссөн бол бараа бүтээгдэхүүнээ гадаадаас импортлодог компаниудын өөрчлөгдөхгүй гэсэн хариулт 14.8 хувиар өссөн нь дотоодын үйлдвэрлэгчдийн итгэл сэргэж, эерэг болсон, гадаадаас бараа импортлодог байгууллагуудын хүлээлт нэг түвшинд байгааг харуулж байна.

Хүснэгт 26. Таны бодлоор ирэх 6 сарын хугацаанд танай компанийн бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт ямар байх вэ?

		Өснө	Өөрчлөгдөхгүй	Мэдэхгүй	Буурна
2010.I	26,3	19,2	42,9		11,7
2010.III	37,0	22,2	29,9		10,9
Өөрчлөлт	10,7	3,0	-13,0		-0,8
2010.I	36,2	14,9	42,6		6,4
2010.III	37,8	29,7	24,3		8,1
Өөрчлөлт	1,6	14,8	-18		1,7
2010.I	40,0	17,8	31,1		11,1
2010.III	37,7	23,2	27,5		11,6
Өөрчлөлт	-2,3	5,4	-3,6		0
2010.I	29,0	18,5	41,5		11,0
2010.III	37,2	23,1	29,0		10,8
Өөрчлөлт	8,2	4,6	-12,5		-0,2

3.2. Ажилчдын тоо болон цалин

Ирэх 6 сард танай компанийн ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 22.6 хувь нь нэмэгдэнэ гэж хариулсан нь өмнөх судалгаанаас 5.4 нэгжээр буурч, 69.2 хувь нь өөрчлөгдөхгүй гэж хариулсан нь 7.2 нэгжээр өсч, 8,2 хувь нь буурна гэж хариулсан нь 1.3 нэгжээр буурчээ. Эндээс харахад шинээр бий болох ажлын байр багасах магадлалтай байна. Харин ирэх 6 сард цалин, хөлсөө нэмэх төлөвлөгөөтэй эсэхийг асуухад 37.7 хувь нь нэмнэ гэж хариулсан нь өмнөх санал асуулгаас 6 нэгжээр өсчээ. Санал асуулгад оролцогсдыг хөрөнгө оруулалтын төрлөөр нь ангилбал гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын цалин хөлсөө нэмэхгүй гэсэн хариулт 42.3 нэгжээр өсч 92.3 хувьд хүрсэн байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдын Монголын эдийн засагт өгөх үнэлэмж, үр ашгийн тооцооны хүлээлт бага байгаа гэж ажиглагдаж байна.

Хүснэгт 27. Ирэх 6 сард танай компани цалин хөлсөө нэмэх төлөвлөгөөтэй байгаа юу?

		Гийм	Үгүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2010.I	29,0	71,0
	2010.III	37,6	62,4
	Өөрчлөлт	8,6	-8,6
Гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	50,0	50,0
	2010.III	7,7	92,3
	Өөрчлөлт	-42,3	42,3
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	57,1	42,9
	2010.III	51,6	48,4
	Өөрчлөлт	-5,5	5,5

	2010.I	31,8	68,2
Бүгд	2010.III	37,7	62,3
	Өөрчлөлт	5,9	-5,9

Цалингаа нэмнэ гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн 34.0 хувь нь 10 хүртэл хувиар, 36.7 хувь нь 11-20 хувиар, 6.1 хувь нь 21-30 хувиар, 0.7 хувь нь 31-40 хувиар, 4.1 хувь нь 41-50 хувиар нэмнэ гэсэн бол үлдсэн 18.3 хувь нь хариулаагүй болон мэдэхгүй гэсэн байна.

Хүснэгт 28. Хэрэв цалингаа нэмэх бол хэдэн хувиар нэмэх вэ?

Өсөлтийн хувь	Тоо	Хувь
1 - 10%	50	34,0%
11 - 20%	54	36,7%
21 - 30%	9	6,1%
31 - 40%	1	0,7%
41 - 50%	6	4,1%
Хариулаагүй	3	2,0%
Мэдэхгүй	24	16,3%
Нийт	147	100%

Цалингийн өсөлтийн хувьд өмнөх санал асуулгын үеэр цалингаа нэмнэ гэж хариулсан байгууллагуудын 23,6 хувь нь 20-30 хүртэл хувиар нэмнэ гэсэн бол энэ удаагийн санал асуулгаар ихэнх нь буюу 70 гаруй хувь 10 хүртэл болон 11-20 хувиар өсгөнө гэж хариулжээ.

3.3. Санхүүжилт болон зээл

Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирэх 6 сарын хугацаанд компаниа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна уу гэж асуухад 46.7 хувь нь тийм, 53.3 хувь нь үгүй гэж хариулсан байна. Хэрэв өргөжүүлж байгаа бол ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх вэ гэсэн асуултанд давхардсан тоогоор өргөжүүлнэ гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн 55.5 хувь нь өөрийн хөрөнгөөр, 31.3 хувь нь банкны санхүүжүүлэлтээр, 10.4 хувь нь гадаад эх үүсвэрээр, 6.6 хувь нь санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр, 3.8 хувь нь тэтгэлэг, тусламжаар, 1.6 хувь нь хувьцаа гаргах замаар санхүүжүүлнэ гэсэн байна.

Танай компанийн зээлийн хэрэгцээ өнгөрсөн 6 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 23.6 хувь нь өссөн, 61.5 хувь нь хэвэндээ байсан, 12.6 хувь нь буурсан, 2.3 хувь нь зээл аваагүй гэж хариулжээ.

Хүснэгт 29. Танай компанийн зээлийн хэрэгцээ өнгөрсөн 6 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?

		Өссөн	Хэвэндээ байсан	Буурсан	Зээл аваагүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2010.I	31,0	57,7	11,3	0
	2010.III	22,8	62,2	12,7	2,3
	Өөрчлөлт	-8,2	4,5	1,4	2,3
Гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	20,8	70,8	8,3	0
	2010.III	30,8	38,5	23,1	7,6
	Өөрчлөлт	10	-32,3	14,8	7,6
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	28,6	57,1	14,3	0
	2010.III	29	64,5	6,5	0
	Өөрчлөлт	0,4	7,4	-7,8	0
Бүгд	2010.I	30,3	58,5	11,2	0,0
	2010.III	23,6	61,5	12,6	2,3
	Өөрчлөлт	-6,7	3,0	1,4	2,3

Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийн зээлийн хэрэгцээг хөрөнгө оруулалтын төрлөөр нь авч үзвэл өнгөрсөн 6 сарын хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын зээлийн хэрэгцээ өнгөрсөн санал асуулгатай харьцуулахад 10 нэгжээр өссөн боловч хэвэндээ болон буурсан гэсэн хариулт 32.3 болон 14.8 нэгжээр буурчээ. Энэ нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд өнгөрсөн 6 сард зээлийн хэрэгцээ нь өөрчлөлт ихтэй байсныг харуулж байна. Харин дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын хувьд зээлийн хэрэгцээ нь бага зэрэг буурчээ.

Зээлийн олдоц өнгөрсөн 6 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ гэж асуухад санал асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийн 19.2 хувь нь сайжирсан, 49.2 хувь нь өөрчлөгдөөгүй, 21.8 хувь нь хэцүү болсон, 9.7 хувь нь зээл аваагүй гэж хариулсан байна. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад сайжирсан гэсэн хариулт 8.9 нэгжээр, өөрчлөгдөөгүй гэсэн хариулт 7.3 нэгжээр тус тус өссөн бол хэцүү болсон гэсэн хариулт 12.7 нэгжээр бууржээ. Эндээс харахад өнгөрсөн 6 сард зээлийн хэрэгцээ буурахын хирээр зээлийн олдоц нэмэгдсэн байна.

Харин ирэх 6 сард танай компанийн зээлийн хэрэгцээ хэрхэн өөрчлөгдөх вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 27.4 хувь нь нэмэгдэнэ гэж хариулсан нь өмнөх судалгаанаас 10.1 нэгжээр буурсан, 55.6 хувь нь өөрчлөгдөхгүй гэж хариулсан нь мөн өмнөх судалгаанаас 2.6 нэгжээр буурсан, 13.3 хувь нь буурна гэж хариулсан нь 3.8 нэгжээр өссөн бол 2.6 хувь нь зээл авахгүй гэж хариулсан байна. Энэ асуултын дүн зээлийн хэрэгцээ ирэх 6 сард өнгөрсөн 6 сарын адил буурах төлөвтэй байгааг харуулж байна.

3.4. Инфляци

Санал асуулгад оролцогсдоос өнгөрсөн 12 сарын хугацаанд түүхий эд болон бусад бараа материал, үйлчилгээнд төлсөн үнэ хэрхэн өөрчлөгдсөн талаар асуухад 27.7 хувь нь их өссөн, 35.6 хувь нь дунд зэрэг өссөн, 24.6 хувь нь бага зэрэг өссөн, 10 хувь нь хэвэндээ байсан гэж хариулсан бол 2.1 хувь нь буурсан гэж хариулжээ.

Аж ахуйн нэгжүүдийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр нь ангилбал бараа бүтээгдэхүүнээ гадаадаас импортолдог компаниудын хувьд өнгөрсөн 12 сарын хугацаанд худалдан авсан түүхий эд болон бусад бараа материал/үйлчилгээнд төлсөн үнэ их өссөн гэсэн хариулт 13 нэгжээр, хэвэндээ байсан гэсэн хариулт 8.9 нэгжээр тус тус буурсан бол бага зэрэг өссөн гэсэн хариулт 16.5 нэгжээр өсчээ. Харин дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг компаниудын хувьд түүхий эд болон бусад бараа материал/үйлчилгээнд төлсөн үнэ өнгөрсөн 12 сарын хугацаанд 9.3 нэгжээр их өссөн бол дотооддоо бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн зэрэгцээ гадаадаас импортолдог компаниудын хувьд үнэ 20.4 нэгжээр дунд зэрэг өссөн байгаа нь түүхий эд болон бараа бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлээс худалдан авах нь гаднаас импортлохоос илүү их үнэтэй байгааг харуулж байна. Энэ нь түүхий эд болон бараа материалаа дотоодын зах зээлээс худалдан авч буй компаниуд гаднаас импортолдог компаниудаас илүү өндөр үнэ төлж байгааг харуулж байна.

Хүснэгт 30. Танай компанийн түүхий эд болон бусад бараа материал/үйлчилгээнд төлсөн үнэ өнгөрсөн 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн бэ?

		Их өссөн	Дунд зэрэг өссөн	Бага зэрэг өссөн	Хэвэндээ байсан	Буурсан
Дотооддоо үйлдвэрлэдэг/үйлчилгээ үзүүлдэг	2010.I	22,4	34,4	24,0	15,9	3,2
	2010.III	31,7	32,7	22,5	10,6	2,5
	Өөрчлөлт	9,3	-1,7	-1,5	-5,3	-0,7
Импортолдог	2010.I	31,9	29,8	21,3	17,0	0,0
	2010.III	18,9	32,4	37,8	8,1	2,7
	Өөрчлөлт	-13	2,6	16,5	-8,9	2,7
Аль аль нь	2010.I	28,9	28,9	26,7	11,1	4,4
	2010.III	15,9	49,3	26,1	8,7	0,0
	Өөрчлөлт	-13,0	20,4	-0,6	-2,4	-4,4
Бүгд	2010.I	24,3	33,3	24,0	15,5	3,0
	2010.III	27,7	35,6	24,6	10,0	2,1
	Өөрчлөлт	3	2,3	0,6	-5,5	-0,9

Ирэх 6 сарын хугацаанд түүхий эд болон бараа материал/үйлчилгээнд төлөх үнэ хэрхэн өөрчлөгдөнө гэж үзэж байна вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 13.6 хувь нь

үнэ илүү хурдацтай өснө, 39 хувь нь үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй, 11 хувь нь үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна, 16.9 хувь нь үнэ өөрчлөгдөхгүй, 2.1 хувь нь үнэ буурна, 17.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Харин ирэх 12 сарын хувьд асуухад санал асуулгад оролцогсдын 10.3 хувь нь үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө, 42.6 хувь нь үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй, 17.4 хувь нь үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна, 11.8 хувь нь үнэ өөрчлөгдөхгүй, 1.5 хувь нь үнэ буурна, 16.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. *Санал асуулгын дүнг хэвийн тархалтын аргаар тооцоход хагас жилийн инфляци 7.1 хувь, жилийн инфляци 6.9 хувь байна.* Энэ нь өмнөх санал асуулгын дүнгээс хагас жилийн инфляцийн хүлээлт 3 нэгжээр, жилийн инфляцийн хүлээлт 2,8 нэгжээр өссөн байна.

Инфляцийн хүлээлтийг тоон утгаар асуухад санал асуулгад оролцогсдын 36.9 хувь нь жилийн инфляци 2-10 хувь, 20 хувь нь 11-20 хувь, 5.6 хувь нь 0-1 хувь, 4.9 хувь нь 21-30 хувь байна гэж хариулсан бол 13.3 хувь нь мэдэхгүй, 14.6 хувь нь хариулаагүй байна.

3.5. Монгол улсын эдийн засгийн байдал, бизнесийн орчин

Ирэх 6 сарын хугацаанд Монгол улсын эдийн засгийн байдал хэрхэн өөрчлөгдөнө гэж бодож байна вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 18.2 хувь нь сайжирна, 27.9 хувь нь өөрчлөгдөхгүй, 18.7 хувь нь муудна, 35.1 хувь нь үнэлгээ өгч мэдэхгүй гэж хариулжээ. Аж ахуйн нэгжүүдийг хөрөнгө оруулалтын төрлөөр нь авч үзвэл гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын сайжирна гэсэн хүлээлт 10 нэгжээр өссөн бол гадаад болон дотоодын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниудын сайжирна гэсэн хүлээлт 24.2 нэгжээр өсчээ. Эндээс харахад гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Монгол улсын эдийн засгийг сайжирна гэж үзэж байгаа бөгөөд үүнийг даган гадны хөрөнгө оруулалт нэмэгдэх эерэг хүчин зүйл ажиглагдаж байна.

Хүснэгт 31. Монгол Улсын эдийн засгийн байдал ирэх 6 сард хэрхэн өөрчлөгдөнө гэж бодож байна вэ?

		Сайжирна	Өөрчлөгдөхгүй	Муудна	Үнэлгээ өгч мэдэхгүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2010.I	15,2	25,6	22,8	36,3
	2010.III	16,8	28,9	19,1	35,2
	Өөрчлөлт	1,6	3,3	-3,7	-1,1
Гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	20,8	8,3	16,7	54,2
	2010.III	30,8	7,7	15,4	46,1
	Өөрчлөлт	10	-0,6	-1,3	-8,1
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	4,8	33,3	14,3	47,6
	2010.III	29,0	25,8	16,1	29,1
	Өөрчлөлт	24,2	-7,5	1,8	-18,5

Бүгд	2010.I	15,0	25,0	22,0	38,0
	2010.III	18,2	27,9	18,7	35,2
	Өөрчлөлт	3,2	2,9	-3,3	-2,8

Харин бизнесийн орчин ямар байна гэсэн асуултанд санал асуулгад оролцогсдын 3.8 хувь нь тааламжтай, 46.7 хувь нь дунд зэрэг, 41.8 хувь нь тааламжтай бус, 7.7 хувь нь үнэлж мэдэхгүй байна гэж хариулжээ. Өмнөх санал асуулгатай харьцуулахад тааламжтай гэсэн хариулт 0,5 нэгжээр, дунд зэрэг гэсэн хариулт 6.7 нэгжээр өссөн бол тааламжтай бус гэсэн хариулт 8 нэгжээр буурчээ.

Хүснэгт 32. Бизнесийн орчин Монголд ямар байна гэж үзэж байна вэ?

		Тааламжгүй	Дунд зэрэг	Тааламжтай бус	Үнэлж мэдэхгүй
Дотоодын хөрөнгө оруулалттай	2010.I	3,7	41,4	49,0	5,9
	2010.III	3,5	47,1	42,8	6,6
	Өөрчлөлт	0	5,7	-6,2	0,7
Гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	8,3	33,3	54,2	4,2
	2010.III	7,7	30,8	38,5	23,1
	Өөрчлөлт	-0,6	-2,5	-15,7	18,9
Дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай	2010.I	9,5	23,8	57,1	9,5
	2010.III	6,5	48,4	32,3	12,9
	Өөрчлөлт	-3,0	24,6	-24,8	3,4
Бүгд	2010.I	4,3	40,0	49,8	6,0
	2010.III	3,8	46,7	41,8	7,7
	Өөрчлөлт	-0,5	7	-8,0	1,7

Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийг хөрөнгө оруулалтын төрлөөр нь ангилбал гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тааламжтай бус гэсэн үнэлгээ 15.7 нэгжээр буурч дотоод болон гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниудын мөн тааламжтай бус гэсэн хариулт 24.8 нэгжээр буурч дунд зэрэг гэсэн хариулт 24.6 нэгжээр өсчээ.

Хүснэгт 33. Бизнесийн орчин Монголд ямар байна гэж үзэж байна вэ?

		Тааламжгүй	Дунд зэрэг	Тааламжтай бус	Үнэлж мэдэхгүй
Дотооддоо үйлдвэрлэдэг/ үйлчилгээ үзүүлдэг	2010.I	4,5	40,3	48,7	6,5
	2010.III	3,9	46,8	41,9	7,4
	Өөрчлөлт	-0,6	6,5	-6,8	0,9
Импортолдог	2010.I	2,1	44,7	48,9	4,3
	2010.III	2,7	51,4	37,8	8,1
	Өөрчлөлт	0,6	6,7	-11,1	3,8
Аль аль нь	2010.I	4,4	33,3	57,8	4,4
	2010.III	4,3	43,5	43,5	8,7
	Өөрчлөлт	-0,1	10,2	-14,3	4,3
Бүгд	2010.I	4,3	40,0	49,8	6,0
	2010.III	3,8	46,7	41,8	7,7
	Өөрчлөлт	-0,5	6,7	-8,0	1,7

Харин бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр нь ялгаж харвал гаднаас импортолдог компаниудын тааламжтай бус гэсэн үнэлгээ 11.1 нэгжээр, дотооддоо үйлдвэрлэхийн зэрэгцээ гаднаас импортолдог компаниудын үнэлгээ 14.3 нэгжээр буурч, дунд зэрэг гэсэн хариулт 10.2 нэгжээр өсчээ. Эндээс харахад Монголд бизнесийн орчин өнгөрсөн санал асуулгатай харьцуулахад гадны хөрөнгө оруулалттай болон гадаадаас бараа бүтээгдэхүүн импортолдог компаниудын хувьд бага зэрэг сайжирсан байна.

4. Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүн


Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн талаарх 4 дэх удаагийн санал асуулгыг 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс 30-ны өдөр хүртэлх хугацаанд явуулсан бөгөөд судалгаанд арилжааны банк, их сургууль болон төрийн байгууллагад ажилладаг эдийн засгийн салбарт туршлагатай нийт 8 шинжээчид оролцов. Шинжээчидтэй утсаар холбогдож, электрон шуудангаар санал асуулгын хуудсаа бөглүүлэх замаар судалгааг авсан.

Уг санал асуулгад эдийн засгийн гол үзүүлэлтүүд (инфляци, бодлогын хүү, M2 мөнгөний өсөлт, төгрөгийн ханш, ДНБ-ий өсөлт)–ийг багтаасан бөгөөд үзүүлэлт бүрийн хувьд улирал болон жилээр хүлээлтийг тооцохоор асуулгыг боловсруулсан. Санал асуулгын хариултыг шууд тоон үзүүлэлтээр авсан бөгөөд шинжээчдийн таамагласан тоон үзүүлэлтүүдийн жигнэсэн дунджийг тооцох замаар хүлээлтийг тооцоолов.

4.1. Инфляци

Шинжээчид жилийн инфляцийг хэрхэн таамагласныг зураг 2-т харуулав. Шинжээчдийн таамаглалаас харахад жилийн инфляци 2010 оны 3-р улиралд 11.9 хувь, оны эцэст 11.7 хувь болохоор таамаглаж байгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад харгалзан 4.7 ба 4.8 нэгжээр хүлээлт өссөн байна. Харин 2011 оноос инфляци нэг оронтой тоонд орж буурах бөгөөд нэг жилийн дараа (2011 оны 3-р улиралд) 9.3 хувь болно гэсэн хүлээлттэй байна.

Зураг 2. Инфляци, шинжээчдийн таамгаар




Улирлын шинж чанараас хамаардаг гурил, мах, сүү зэрэг өргөн хэрэглээний барааны үнэ буурсан, төгрөгийн ам.доллартай харьцах ханш чангарч байгаа зэрэг нь энэ оны 7 дугаар сарын байдлаар инфляци 8.3 хувьд болж буурахад нөлөөлсөн ч Засгийн газраас 2010 оны 10 дугаар сард төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн, мөн хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотой сургалтын төлбөр нэмэгдэх хандлага үргэлжилбэл боловсролын бүлгийн үнийн индекс өсч энэ оны сүүлийн хагаст үнийн ерөнхий түвшинг өсгөх хандлагатай байна. Харин 2011 оноос Төсвийн хариуцлагатай

байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор төсвийн зардалд хязгаарлалт тавигдсанаар инфляцийг бууруулах магадлалтай юм.

4.2. Бодлогын хүү

Бодлогын хүүг шинжээчид хэрхэн таамагласныг зураг 3-т харуулав. Шинжээчид бодлогын хүүг 2010 он дуустал тогтмол 10.5 хувь байхаар таамагласан бол 2011 оноос буурч 9.6-9.8 хувь болохоор төсөөлж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 2010 оны 3 ба 4-р улирлын таамаглал тус бүр 0.7 нэгжээр өссөн байна.

Зураг 3. Бодлогын хүү, шинжээчдийн таамгаар




4.3. Мөнгөний нийлүүлэлт

Шинжээчид M2⁹ мөнгөний жилийн өсөлтийг хэрхэн таамагласныг зураг 4-т харуулав. Шинжээчдийн таамаглалаар 2010 оны 3-р улиралд M2 мөнгөний өсөлт 36.9 хувь болж өмнөх улирлаас 7.6 нэгжээр буурна гэж тооцоолж байна. Харин 2011 оны 1-р улирал дуустал M2 мөнгөний өсөлт нэмэгдэх бол 2-р улирлаас эхэлж буурах буюу өсөлтийн хурд тогтмол -1 хувьтай байхаар таамаглажээ.

Өмнөх судалгаатай харьцуулахад 2010 оны 3-р ба 4-р улирлын таамаглал харгалзан 10.2 нэгж ба 10.6 нэгжээр өссөн байна.

⁹ M2 мөнгө- банкнаас гадуурхи *МӨНГӨ*, иргэд байгууллагын төгрөгийн харилцах данс ба бараг мөнгөний нийлбэр

Зураг 4. M2 мөнгөний өсөлт, шинжээчдийн таамгаар




4.4.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг шинжээчид хэрхэн таамагласныг зураг 5 ба 6-д харуулав. Шинжээчдийн таамаглалаар төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш тогтмол чангарч, 2010 оны 3-р улиралд 1355.0 төгрөг, жилийн эцэст 1342.8 төгрөг болохоор тус тус тооцоолж байна.

Өмнөх судалгаатай харьцуулахад 2010 оны 3-р улирлын ханшийн хүлээлт 4.7 хувь, 4-р улирлынх 5.4 хувиар тус тус буурсан байна.


Манай улсын гадаад худалдааны нөхцөл сайжирч, уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагаа улам идэвхжих хандлагатай уялдан эдийн засагт гадаад валютын цэвэр орох урсгал өссөнтэй холбоотойгоор төгрөгийн ханш чангарч байгаа нь цаашдын ханшийн хүлээлтийг бууруулж байна.

Зураг 5. Төгрөг/долларын нэрлэсэн ханш, шинжээчдийн таамгаар



Харин төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханшийн таамгаас харахад 2 ба 4-р улирлуудад чангарч, 1 ба 3-р улирлуудад суларна гэж төсөөлж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 2010 оны 3 ба 4-р улирлын таамаглал 5.1 ба 6.4 хувиар тус тус буурсан дүнтэй байна.


Зураг 6. Төгрөг/юанийн нэрлэсэн ханш, шинжээчдийн таамгаар



4.5. ДНБ-ий өсөлт

ДНБ-ий өсөлтийг шинжээчид хэрхэн таамагласныг зураг 7-д харуулав. Шинжээчдийн таамаглалаар ДНБ-ий өсөлт 2010 оны 1-р улиралд 5.1 хувь, жилийн эцэст 5.9 хувьд хүрч өсөх бол 2011 оны 1-р улиралд буураад, 2-р улирлаас эхлэн өсөхөөр таамаглаж байна.

Зураг 7. ДНБ-ий өсөлт, шинжээчдийн таамгаар



Өмнөх судалгаатай харьцуулбал 2010 оны 3-р улирлын таамаглал 0.4 нэгжээр, 4-р улирлынх 0.2 нэгжээр тус тус буурсан байна.

2010 оны эхний 7 сарын аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээнээс харахад тухайн салбарт өндөр өсөлт гарсан бөгөөд цаашид энэ байдал хадгалагдан үлдэж үлдсэн саруудад тус салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ өсөх хандлагатай байгаа нь 2010 оны 2 дугаар улиралд саараад байсан ДНБ-ий өсөлтийн хурдыг эрчимжүүлнэ гэж тооцож байна. Үүнтэй уялдаад 2010 оны сүүлийн хагаст ДНБ-ий өсөлт нэмэгдэхээр байна.

5. Дүгнэлт

Инфляцийн хүлээлтийн 4 дэх удаагийн санал асуулгыг 2010 оны 3-р улиралд Улаанбаатар хотноо явуулж дүгнэлээ. Энэ удаагийн санал асуулгад Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн 1000 иргэн, Улаанбаатар хотод бүртгэлтэй 390 аж ахуйн нэгжүүд, мөн 8 шинжээчид оролцлоо.

Иргэдийн инфляцийн хүлээлт өмнөх судалгааны дүнгээс өсч оны эцэст **8.2** хувь, жилийн дараа гэхэд **8.6** хувь байхаар байна. Харин ААН-ийн инфляцийн хүлээлт оны эцсийн байдлаар **7.2** хувь, жилийн дараа гэхэд **6.9** хувь, шинжээчдийн хүлээлт 3-р улирлын эцэст **11.9** хувь, оны эцэст **11.7** хувь болохоор байна. Харин Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийг жилийн 8.0 хувиас хэтрүүлэхгүй байх зорилт тавьсан байгаа юм.

2009 он хямралын хамгийн хүнд жил байлаа. Манай улсын хувьд сүүлийн арав гаруй жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт эерэг байсан ч өнгөрсөн жилд 1.6 хувийн бууралттай гарсан нь дэлхийн хөгжиж буй орнууд дундаа хямралд нэлээд хүнд өртсөн орны тоонд зүй ёсоор орж байна¹⁰. Мөн санал асуулгын дүнгээр ч энэ нь батлагдан харагдаж байна.

Иргэдийн ихэнх хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд манай улсын эдийн засгийн байдал муудсан, бараг тал хувь нь ирэх жил хэвэндээ байна, муудна гэсэн хариултуудыг өгсөн хэвээр байгаа боловч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад багагүй хувиар буурч байна. Түүнчлэн судалгаанд оролцсон иргэдийн ихэнх нь Засгийн Газар эдийн засгийн байдлыг сайжруулах арга хэмжээ авч чадахгүй байна, ирэх нэг жилийн хугацаанд ажилгүйдэл нэмэгдэнэ гэж үзсэн ч өмнөхөөс дунджаар 10.0-11.0 нэгжээр буурсан дүнтэй байна. Эндээс харвал санхүү, эдийн засгийн хямралаас үүдсэн хүлээлт иргэдийн дунд байсан хэвээр байгаа боловч Монголын эдийн засаг сэргэх төлөв байдал ажиглагдаж эхэлсэнтэй холбогдуулан сөрөг хариултуудын хувь хэмжээ буурч байна.

Харин зээл, хадгаламжийн талаар асуухад иргэдийн талаас илүү нь ирэх нэг жилийн хугацаанд зээлийн хүү хэвэндээ байх бөгөөд үүнээс илүү өснө, бараг тал хувь нь хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжгүй бөгөөд томоохон хэмжээний худалдан авалт хийх үе биш хэмээн үзэж байна. Иргэдээс өрхийн санхүүгийн байдлын талаар асуухад гуравны нэг нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд муудсан гэж хариулсан бөгөөд тэдгээрээс тал гаруй нь үнэ өссөнөөс, гуравны нэг нь өрхийн гишүүд ажилгүй болсноос, дөрөвний нэг нь бизнесийн орлого буурснаас, тавны нэг нь цалин буурснаас шалтгаалж өрхийн санхүү муудсан гэж хариулсан байна. Харин ирэх нэг жилийн хугацаанд иргэдийн дөрөвний нэг нь өрхийн санхүүгийн байдал сайжирна, дөч гаруй хувь нь хэвэндээ байна, 6 хувь нь муудна гэж үзжээ. Сайжрана гэсэн иргэдийн дийлэнх нь бизнесийн орлого өснө, ажлын байртай болно, цалин нэмэгдэнэ гэж үзсэн байна.

¹⁰ Нээлттэй нийгэм форум. 2010, “Дэлхийн санхүү эдийн засгийн Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө”

Энэ удаагийн ААН-ийн санал асуулгаар бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт нэмэгдсэн, зээлийн олдоц сайжирсан, ирэх 6 сарын эрэлтийн хүлээлт өндөр байгаа боловч зээлийн эрэлт буурсан, шинэ ажлын байр нэмэгдэх төлөв ажиглагдахгүй байна. Өмнөх санал асуулгатай харьцуулахад цалин нэмэгдэх боловч цалингийн өсөлтийн хувь 10 нэгжээр буурчээ. Санал асуулгад оролцогсдыг хөрөнгө оруулалтын төрлөөр нь авч үзвэл дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудын хувьд бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлтийн хүлээлт илт сэргэсэн байгаа нь эдийн засагт гарч буй нааштай үзүүлэлт юм.

Харин Монгол улсын эдийн засгийн байдал, бизнесийн орчинд гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд илүү өндөр үнэлгээ өгсөнөөс гадна ирэх 6 сард сайжирна гэсэн хүлээлт өндөр байгаа нь үүнийг даган гадны хөрөнгө оруулалт нэмэгдэх эерэг дүр зураг ажиглагдаж байна. Өнгөрсөн 12 сарын хугацаанд түүхий эд болон бусад бараа материал/үйлчилгээнд төлсөн үнэ дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудын хувьд өндөр байгаа нь импортын бүтээгдэхүүн дотоодын зах зээлд үнэ нь их хэмжээгээр нэмэгдэж зарагддагтай холбоотой бөгөөд энэ нь дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудын ашгийг бууруулдаг төдийгүй Монголд бизнесийн орчин тааруу байна гэсэн үнэлэмж өгөхөд нөлөөлсөн байна.

Шинжээчдийн таамаглалаас харахад дэлхийн эдийн засаг сэргэж байгаатай холбогдон манай улсын эрдэс баялгийн бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ өсч, хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэн валютын нөөц, төсвийн орлого ихээхэн өссөнөөр гадаад валютын эсрэг төгрөгийн ханш чангарах, эдийн засгийн өсөлт нэмэгдэх хүлээлттэй байна. Мөн зээлийн тасалдлыг зогсоож, бодит салбарыг дэмжихийн тулд бодлогын хүү буурч, мөнгөний нийлүүлэлт өснө гэсэн таамаглалтай байна. Гэсэн хэдий ч цалингийн өсөлт, улирлын шинж чанартай эрэлт, хүнсний нийлүүлэлтийн байдал зэргээс хамаарч 2010 онд инфляци өсөх магадлалтай байна. Харин 2011 онд инфляци болон эдийн засгийн өсөлт 2010 оныхоос буурхаар таамаглаж байна.